

ТӨВ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*ҮАГ-ын Нийцлийн Аудитын газрын 2014 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний
төлөвлөгөөний дагуу хийсэн нийцлийн аудитын тайлан*

**ЭРҮҮЛ МЭНДИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	
ҮАГ-ын харьяа Төв аймгийн аудитын газар	Товчилсон үгсийн тайлбар3 Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй4-5
Дарга, тэргүүлэх аудитор Л.Жаргалсайхан	Бүлэг 1 1.1 ЗГ-ын гаргасан тогтоол, тушаал, шийдвэр, дүрэм журам нь МУ-ын хууль тогтоомжтой нийцэж байна уу?6 1.2 Аяны үйл ажиллагааг зохион байгуулах хөрөнгийг бодитой төлөвлөсөн үү?.....6
Аудитын менежер О.Амаржаргал	
Аудитор Г.Бадар-Ууган	Бүлэг 2 Дүгнэлт.....13 Зөвлөмж.....14
2014 оны 04 дугаар сарын 15	Холбогдох байгууллагын санал: Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал15
Уг тайланг АГ-ын Веб сайт-аас үзнэ үү.	
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70272582, 70283204 дугаарын утас, 0127222582 дугаарын факсаар харилцана уу ХАЯГ:	
Төв аймгийн Төрийн байгууллагын ордон	

Товчилсон үгийн тайлбар

СТСХ	Санхүү Төрийн Сангийн хэлтэс
ААГ	Аймгийн аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
АШБ	Анхан шатны баримт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨАГ	Төв аймгийн Аудитын газар
АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЭМС	Эрүүл мэндийн сайд
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ЭХЭМТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн төв

1.Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторт 2013 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлогдсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

2. Аудитын зорилт

Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны төлөвлөлт, эх үүсвэр бодитой байна уу?
- Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө хууль журмын дагуу зарцуулагдаж байна уу?
- Сангийн үйл ажиллагаанд тавих хяналт үр дүнтэй байна уу?

3. Аудитын хамрах хүрээ

Төв аймгийн ЭМГ-ын 2013 оны эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны санхүүгийн баримт материал холбогдох бусад материалууд хамрагдсан болно.

4.Аудитын арга зүй

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгааны дүнг харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг ашиглана. Төрийн хяналт шалгалтын стандарт, аудитын гарын авлагад дурдсан аудитын арга зүйг мөрдөж, аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

5.Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана.

- Засгийн газрын тусгай сангийн тухай хууль
- Эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэм

6. Аудитын хугацаа, тайланд тусгагдах мэдээлэл

Аудитыг 2014 оны 04 дүгээр сарын 01-нд эхэлж, 2014 оны 05 дүгээр сарын 01-ны өдөр дуусгав.

Аудитын тайланд аудитын зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, хавсралт судалгаа, холбогдох байгууллагын саналыг хавсаргалаа.

7. Аудит хийх бүрэлдэхүүн

Аудитыг Төв аймгийн АГ-ын аудитын менежер О.Амаржаргал удирдан аудитор Г.Бадар-Ууган аудитын төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Бүлэг 1

Аяны үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу явагдсан байна.

1.1 Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг журмын дагуу зарцуулсан эсэх

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр гүйцэтгэх 17 ажлыг зохион байгуулахаар Эрүүл мэндийн сайдтай байгуулсан хамтран ажиллах гэрээний дагуу Төв аймгийн Засаг даргын хөрөнгө зарцуулах тухай 2014 оны А/492 тоот захирамж гаргуулан хийгдэх ажлын төлөвлөгөө зарцуулагдах хөрөнгийн төсөв хэмжээг батлуулсан байна. Тус төлөвлөгөөнд тусгагдсан зохион байгуулагдах ажилд нийт 31054.3 мянган төгрөгийн хөрөнгө төсөвлөгдөж батлагдсан ба эрүүл мэндийн сайдтай байгуулсан гэрээнд “нийт санхүүжилтийн 60 хувийг санхүүжүүлнэ” гэж заасан боловч гүйцэтгэлээр 24000.0 мянган төгрөгийг олгосон байна. Үүнд аймгийн эмнэлгийн мэргэжилтний чадавхийг бэхжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр хийж буй ажлын туршлага судалсан үйл ажиллагаа, аймгийн сумдын эх нялхсын эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээний чанарыг сайжруулах зорилгоор бүсийн сургалтыг, Улаанбаатар хотын ЭХЭМТ-ийн хүүхдийн төв сувилалд сумдын төрөлт олонтой сумдын эх баригч нарыг мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, ажлын байран дахь дадлага сургалтанд хамруулан тус сургалтуудын хүрээнд томилолт, шатахууны зардлыг эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөнөөс зохих журмын дагуу олгож, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажилласан байна.

Мөн аймгийн Эрүүл мэндийн тулгамдсан асуудал 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр шат шатны шийдвэр гаргагчдад “эх хүүхдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа” зөвлөгөөнийг зохион байгуулж тус зөвлөгөөнд 100 хүн хамрагдаж 3466.9 мянган төгрөг зарцуулсан байна. Тус зөвлөгөөнөөр гарсан зардлаас 1244.0 мянган төгрөг нь хоол, цайны зардалд, 140.0 мянган төгрөг нь зөвлөгөөн зохион байгуулсан байрны түрээс, бичиг хэргийн зардалд 547.6 мянган төгрөг, томилолтын зардалд 1109.5 мянган төгрөг, бусад холбогдох зардалд 120.0 мянган төгрөгийн зардлыг тус тус зарцуулан баримтын бүрдлийг хангаж ажилласан байна.

Нийтийн биеийн тамир, идэвхтэй хөдөлгөөний ач холбогдлын талаар мэдээлэл сургалт сурталчилгааг явуулах зорилгоор эрүүл мэндийг дэмжигч байгууллага шалгаруулах, хөдөлгөөний ач тус сэдэвт аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын бүсчилсэн спортын нэгдсэн арга хэмжээ, өглөөний алхалт, өглөөний цай өдөрлөг зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулж тус арга хэмжээнд нийт 2625.5 мянган төгрөгийн зардал гаргаснаас шагналд 1241.8 мянган төгрөг, цом өргөмжлөл, анноас хийлгэх зардалд 428.4 мянган төгрөг, шагналаас суутгасан татварт 112.5 мянган төгрөг, 367.5 мянган төгрөгийг тамирчдын хоол, шүүгчдийн хөлс, 475.3 мянган төгрөг нь мөн хоолны материалын зардалд тус тус зарцуулсан байна.

Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх ажилд идэвхтэй оролцож үр дүнд хүрсэн төрийн бус байгууллага хуулийн этгээд иргэдийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зохион байгуулсан архи тамхины хэрэглээ, тэдгээрийн нийгэм эдийн засагт учруулах сөрөг үр дагавар болон зан үйлийн

өөрчлөлт, ажлын байрны эрүүл хэвшилд нэгдэцгээе зэрэг аяныг аймгийн ЭМГ, сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зөвлөл, Дэлхийн зөн ОУБ-ын төв орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Төрийн болон Төрийн бус байгууллага, ААНБайгууллагуудтай хамтран зохион байгуулсан сургалт, тэмцээний шагналд зориулан эрүүл мэндийг дэмжих сангийн төсвөөс батлагдсан төсөвт багтаан зарцуулсан байна.

Аймгийн ЭМГазар нь байгууллага нь иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээ мэдээллүүдийг тогтмол явуулах зорилгоор АИ ТИ ЭС ӨҮ ХХК-аас материал нийлүүлэх гэрээ хийж сурталчилгааны урсах самбар 1320.0 мянган төгрөгөөр хийлгэж байгууллагын гадаах орчинд байрлуулан мэдээлэл сурталчилгааг тогтмол хийж байна.

Нийт зарцуулагдсан хөрөнгөнд дийлэнх хувийг эзэлж байгаа зардлуудыг дурьдвал болзолт уралдаан тэмцээний шагналд 5840.3 мянган төгрөг буюу 24.6 хувь зарцуулагдсан, 16.4 хувь буюу 3893.3 мянган төгрөгийн зардал нь сургалт, семинар, зөвлөгөөн уралдаан тэмцээний шагналд, 3967.0 мянган төгрөг буюу 16.7 хувийг албан томилолтын зардалд, 1531.0 мянган төгрөг буюу 7.2 хувийг шатахууны зардал, 4.6 хувь буюу 1098.0 мянган төгрөгийг хөтөлбөртэй холбогдон гарсан цалин урамшууллын зардал тус тус эзэлж байна. Нийт санхүүжигдсэн 24000.0 мянган төгрөгөөс батлагдсан арга хэмжээнүүдийг санхүүжүүлэн гүйцэтгэлээр нийт 21287.9 мянган төгрөгийн зардал гаргаж 2712.1 мянган төгрөгийг хэмнэсэн боловч жилийн эцэст хөтөлбөр төсөлд батлагдаагүй 2439.0 мянган төгрөгийг шатахууны зардалд шилжүүлэн зориулалт бусаар зарцуулж 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 273.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг төлөвлөгөөнд батлагдсан төсөвт багтаан Засгийн газрын тусгай сангийн тухай хууль болон Засгийн газрын эрүүл мэндийг дэмжих сангийн дүрэмд заасан арга хэмжээг төлөвлөж баталуулж арга хэмжээг явуулсан боловч тухайн явуулсан арга хэмжээний хоол цай болон томилолт, арга хэмжээг сурталчилах үйл ажиллагааны тэмцээний шагнал, шатахуун, төсөл хөтөлбөрт оролцсон ажилчдын урамшуулал зэрэгт зарцуулагдсан байна.

1.2 Эрүүл мэндийг дэмжих сангийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу явагдсан уу

2013 оны 08 сарын 21-ний өдрийн Эрүүл мэндийн сайд, ЭМГ-ын даргатай байгуулсан хамтран ажиллах 20 тоот гэрээг үндэслэн Төв аймгийн Засаг даргын 2013 оны 09 сарын 11-ний өдрийн эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө зарцуулах тухай А/492 тоот захирамжаар аймгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх, хянах чиглэлээр хийх ажлын удирдамж, эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр зохион байгуулах ажлын төлөвлөгөөг баталсан байна. Тус төлөвлөгөөнд гурван бүлэг бүхий 17 төрлийн ажлын төлөвлөгөөг гаргаж, шалгуур үзүүлэлт, шаардагдах төсөв, хийгдэх хугацааг зааж өгсөн байна.

Эрүүл мэндийг дэмжих сангийн санхүүжилтээр хийх ажлын үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу эх нялхсын тусламж үйлчилгээгээр тэргүүний байгууллага, аймаг орон нутагт явж туршлага судлах ажлаар Сэлэнгэ аймгийн ЭМГ-ын үйл ажиллагаатай танилцаж Төв аймгийн ЭМГ-ын 10 ажилтан тус туршлага судлах үйл ажиллагаанд оролцсон байна. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгө нь Төв аймгийн ЭМГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд 8-р сарын 28-нд орж ирсэн ба тайланд онд явуулах хөтөлбөрийн жагсаалтыг шахуу хийгдэж ирсэнээс 17 ажлыг санхүүжилт батлагдаж орж ирсэн өдрөөс хойш аймгийн Эрүүл мэндийн газар, аймгийн Нэгдсэн эмнэлгийн төлөөлөл болох 10 эмч мэргэжилтэнүүд Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн газрын болон нийгмийн эрүүл мэндийн үйл ажиллагаа, эрүүл мэндийг дэмжих чиглэлээр

хийж буй ажлын туршлага судлан эх нялхсын эрүүл мэндийн чиглэлээр хийж буй дэвшилттэй ажлуудыг судалж орон нутагтаа хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, эх нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх тусламжийн чанарыг сайжруулах талаар сумын иргэдэд эх хүүхдийн эрүүл мэндийн талаар мэдээлэл өгч мэдлэгийг бататгах зорилгоор АХА тэмцээн зохион байгуулсан байна.

Төв аймгийн ЭМГ, Батсүмбэр, Баян, Баянчандмань, Борнуур, Бүрэн, Дэлгэрхаан, Жаргалант, Заамар, Лүн, Угтаал, Эрдэнэсант сумдын эх баригч нар нялхсын клиник сувилалын үйл ажиллагаатай танилцаж нярайн яаралтай тусламж асаргаа, сувилгаа, сэхээн амьдруулалт сэдэвт сургалтанд хамрагдаж үр дүнг тооцож ажилласан байна.

Эх хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах чиглэлээр гарсан нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр, эх нярайн эрүүл мэнд 2011-2015 оны стратеги хүүхдийн эсэн мэнд амьдрахуй стратегийн хэрэгжилтийг хангах, эх, хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд зорилгоор 2013 оны 12 сарын 13-нд эх хүүхдийн эрүүл мэндийн төлөө хамтдаа аймгийн зөвлөгөөний удирдамжийг аймгийн Засаг даргаар батлуулсан хөтөлбөрийн дагуу ЭМЯамны мэргэжилтнүүд, ЭМШУИСургуулийн багш нартай хамтран сум багийн засаг дарга нар, сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч нарын дунд зохион байгуулж нийт 100 хүнийг хамруулж эх хүүхдийн эрүүл мэндийн өнөөгийн тулгамдсан асуудлаар сум орон нутгийн удирдах албаны хүмүүс тодорхой ойлголттой болгож эх хүүхдийн эрүүл мэндийн стратегийн хэрэгжилт манай аймгийн хувьд улс орны түвшинд ямар хэрэгжилттэй явж байгаа талаар, цаашид юун дээр анхаарч ажиллах талаар мэдээ мэдээлэл авсан байна.

Аймгийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах, нярайн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг дэмжих, урьдчилан сэргийлэх, хянах ажлын төлөвлөгөөний дагуу 4 бүсийн хооронд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах нь сэдэвт болзолт уралдааныг зохион байгуулж тус уралдаанаар хийх ажлын төлөвлөгөөг баталсан байна. Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийт 9 ажил хийхээр төлөвлөж төлөвлөгөөний дагуу хэрэгжилтийг тооцож ЭМБ-ын 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн судалгааг гаргаж цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гаргасан байна. Тус болзолт уралдаанд шалгарсан 7 сумыг эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөс тус бүр 300.0-500.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан байна.

Эх барих эмэгтэйчүүдийн эмч нар, өсвөр үеийн төвийн эмч, зохицуулагч, сайн дурын идэвхитэн нар хамтран Төв аймгийн ЕБСургуулийн ахлах сургуулийн 10-11 дүгээр ангийн сургачид, МСҮТөвийн оюутан залууст бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн 4 сэдвээр 2 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулсан байна. Мөн Эрдэнэ сумын ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид болон МСҮТөвийн дотуур байрны оюутнуудад нөхөн үржихүйн талаар 4 сэдвээр 3 удаагийн сургалт зохион байгуулж сургалтанд хамрагдсан оролцогчдын судалгааг гаргаж сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн үзүүлэлтийг харицуулан үр дүнг тооцож ажилласан байна. Дээрх сургалтуудын үеэр заасан хичээл танин мэдэхүйн асуултуудаар АХА тэмцээнийг зохион байгуулж амжилттай оролцсон хүүхдийг шагнаж урамшуулсан байна.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн дасгал хөдөлгөөний чиглэлээр сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд Улаанбаатар хотод байрлах SYNERGY сургалтын төвд АНЭ-ийн төрх тасгийн 3 эх баригчийг жирэмсэн ээжүүдэд дасгал хөдөлгөөн заах сургагч багшаар 3 өдрийн сургалтанд хамруулан аймгийн өрхийн эрүүл мэндийн төв болон сумын эрүүл мэндийн

төвийн эх баригч, сувилагч нарт жирэмсний үеийн дасгал хөдөлгөөний чиглэлээр сургалт хийсэн байна.

Зуунмод сумын 0-3 настай хоол тэжээлийн архаг дутал болох рахит, цус багадалт, тураал, сульдаатай цэцэрлэгт хамрагддаггүй хүүхдүүдийн хоол засал сувилгаа аминдэм эмчилгээний хүрээнд Зуунмод сумын 0-3 настай 20 хүүхдийг ЭМГ, АНЭ, Баруун-Зуунмод, Биндэрьяа өрхийн эрүүл мэндийн төвийн эмч сувилагч нарын 6 бүрэлдэхүүнтэй 20 хооллолтын бэрхшээлтэй хүүхдүүдийн сонгож эцэг эх асран хамгаалагчлыг өдөр бүр хооллолтын сувилгаанд хамруулахыг зөвлөн, зохион байгуулагдах үйл ажиллагаа, ач холбогдлыг танилцуулж гарын авлагаар хангаж ажилласан байна.

Батлагдсан төлөвлөгөөний дагуу ажлууд хугацаандаа хийгдэж, хийгдсэн ажлуудыг тухай бүр фото зургаар баталгаажуулан холбогдох баримтын бүрдлийг хангаж ажилласан байна.

Эрүүл мэндийг дэмжих сан

Бүлэг 2

Сангийн хөрөнгөнд дотоод хяналт шалгалтыг огт хийгээгүй байна.

2.1 Сангийн хөрөнгө зарцуулалтанд дотоод хяналт хийсэн үү

Аймгийн Эрүүл мэндийн газрын 2013 оны 04 сарын 18-ний а/46 тоот тушаалаар эрүүл мэндийн болон санхүүгийн холбогдолтой хууль тогтоомж, дүрэм, журам, удирдах дээд байгууллагуудын шийдвэрүүд, стандартын хэрэгжилт, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэл, төсвийн зарцуулалт, төсвийн хөрөнгөөр худалдаж авсан бараа материал, багаж тоног төхөөрөмжийн чанар, ашиглалт өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх эрх бүхий Дотоод хяналтын баг-ийг томилсон боловч санхүүгийн үйл ажиллагааны зарцуулалт болон эрүүл мэндийг дэмжих сангийн зарцуулалтанд дотоод хяналт шалгалтыг огт хийгээгүй байна.

2.2 Сангийн үйл ажиллагаанд хяналт тавьж байгаа эсэх

Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгөөр явуулах төсөв удирдамжийг хариуцсан мэргэжилтэн нар байгууллагын дарга, нягтлан бодогчоор хянуулан батлуулж холбогдох гүйлгээг хийж хэвшсэн байна. Хийгдсэн ажлын талаар хариуцсан мэргэжилтэн бүр холбогдох тайлан судалгааг гаргаж үр дүнг тооцож ажилласан байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт өгч байна.

1. Эрүүл мэндийг дэмжих сангийн хүрээнд явагдаж байгаа аливаа ажлын холбогдох зардлын ихэнх хувийг уралдаан тэмцээний шагнал, хоол цай, томилолтын зардалд зарцуулагдсан байна.
2. Эрүүл мэндийг дэмжих сангаас гарсан зардлын холбогдох анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангаж, хийгдсэн ажил бүрийг фото зургаар баталгаажуулан ажилласан байна.
3. Сангийн хөрөнгөөс зориулалт бусаар шатахууны зардал гаргасан байна.
4. Сургалтанд ашиглахаар авсан хөрөнгө материалуудыг орлогод авч данс бүртгэлд тусгаж ажилласан байна.
5. Сангийн хөрөнгө зарцуулалтанд дотоод хяналтыг огт хийгээгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн аймгийн Эүүл мэндийн газрын удирдлагад дараах зөвлөмжийг өгч байна:

1. Сангийн хөрөнгөнөөс зориулалт бусаар зарцуулахгүй байх.
2. Сангийн хөрөнгийн зарцуулалтанд дотоод хяналт шалгалт хийж байх
3. Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг шагнал, урамшуулалд зарцуулахгүй байх.

Аудитор

Г.Бадар-Ууган

Холбогдох байгууллагын санал

Холбогдох байгууллагын санал

